

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН 03 ДУГААР САРЫН
1 ДЭХ ДОЛОО ХОНОГИЙН МЭДЭЭ

2019.03.07

	Хоногийн товч мэдээ	Дараагийн 7 хоногт шийдвэрлэв эл зохих асуудал	Бусад асуудал
1	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Баян-Өлгий аймгийн Засаг даргатай 2019 онд Байгаль орчин, Аялал жуулчлалын салбарт хамтран ажиллах №19-001 тоот гэрээний 1 дүгээр хавсралтын 4 дэх хэсэг болон Амьтны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.8 био техникийн арга хэмжээ авч хэрэгжүүлэх талаар заасны дагуу туурайтан амьтны хаваржилтын байдал хүндэрсэн бүс нутаг болох Улаанхус сумын “Баянзүрх” агнуурын бүс нутгийн “Бага асгант”, “Хараа сай”, Толбо сумын “Сайр”, “Борт уул”-ын “Мейрим дараа”, Ногооннуур сумын “Тангад” “Модон овоо” агнуурын бүс нутгийн “Түнхэт”, “Хөндий хад”, “Ямаатын уул”, Сагсай сумын “Турган”, “Хагалгат” ангийн бүс нутгуудад Байгаль орчин аялал жуулчлалын газрын даргын 2019 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн Б/10 тоот тушаалаар байгуулсан ажлын хэсэг нь өвс, давс тавьж био техникийн арга хэмжээ авч хэрэгжүүлэх ажлуудыг тус тус зохион байгууллаа		
2	Нэг иргэн, нэг аж ахуйн нэгжийн төсөлд БОНБЕҮнэлгээний дүгнэлт гаргав.		
3	Аймгийн татварын хэлтэстэй хамтран байгалийн нөөц ашигласаны төлбөрийн тухай хуулийн Рашаан болон Байгалийн ургамлын нөөц ашигласаны төлбөрийн дэд хязгаар тогтоох талаар аж ахуйн нэгж байгууллагад хэлэлцүүлэг зохион байгууллаа.		
4	Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 189 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2019 оны 03-р сарын 01-ний өдрөөс эхлэн 0.035 мм нимгэн нэг удаагийн нийлэг хальсан уутыг худалдаа үйлчилгээнд хэрэглэхийг хориглосонтой холбогдуулан БОАЖГ, МХГ, МАНУТХГХЗахиргаатай хамтран аймгийн төвийн дэлгүүрүүдэд сарын удирдамжийн дагуу хяналт шалгалт хийж, Дөрвөс телевизээр сурталчилах ажлуудыг зохион байгууллаа.		
5	Өвлийн аялал жуулчлалыг улсын хэмжээнд хөгжүүлэх зорилтын хүрээнд Байгаль орчин аялал жуулчлалын яам, Баян-Өлгий аймгийн Засаг даргын Тамгын газар, Байгаль		

	орчин аялал жуулчлалын газар ,Нийслэлийн аялал жуулчлалын газар ,Монголын Аялал жуулчлалын холбоо, Баян-Өлгий аймгийн Бүргэдчдийн холбоо,Улаанбаатар хот дахь Баян –Өлгий аймгийн Нутгийн зөвлөл, “Чингисийн Хүрээ” Аялал жуулчлалын цогцолбортой хамтран Улаанбаатар хотод “Нүүдэлчдийн өвөл –Бүргэдийн баяр 2019” арга хэмжээг 13 дахь жилдээ зохион байгууллаа.		
6	Дэлхийн усны өдрийн хүрээнд Хар нуур Ховд голын сав газрын захиргаатай хамтран Өлгий сумын хэмжээнд ус ашиглагч аж ахуйн нэгж байгууллагуудын төлөөллүүдийг оролцуулан “Ус амьдралын үндэс” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгууллаа.		
7	Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлыг орон нутагт зохион байгуулах ажлын хүрээнд Монгол Улсын Шадар сайд, <u>БОАЖСайдын</u> хамтарсан тушаал болон <u>БОАЖ-ын</u> дэд сайд, Ой хээрийг түймрээс хамгаалах үндэсний зөвлөлийн даргын зөвлөмжийг сум орон нутагт хүргүүлэн сурталчлах ажлыг зохион байгуулж байна.		

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР